

Баяд угсаатны хүн ам зүйн судалгаа

О. Сүхбаатар

Хүн судлалын төв

Судлаач

Хяргас сум нь Увс аймгийн төвөөс зүүн тийш 180 километр зайд, Хан Хөхийн нурууг дамнасан уулын ойт хээр, хээрийн бүсэд оршино. Сумын нутгийн тэг дундуур далайн төвшнөөс 2591 метр өргөгдсөн Бүр Хайрхан уул зэрэг Хан Хөхийн гол нурууны хэсэг баруунаас зүүн тийш нэвт өнгөрөх ба гол нуруунаас хойш ургаш салбарласан 1800–24500 м өргөгдсөн дундаж уулстай. Хан Хөхийн нуруу энэ хэсэгтэй зам харилцаанд төдий л бэрхшээлтэй бүс учраас малчдын нүүдэлд тохиромжтой нутаг юм. Гол нуруунаас хойшхи салбар уулсын бэл хаяа 1300–1600 м өндөр, талархаг толгодлог гадаргуутай, буюу Хяргас Хан Хөхийн нурууны өмнөд бэл буюу Хяргас нуурын хөндий нь далайн төвшнөөс 1028 метр өргөгдсөн толгодлог, говирхог талын байдалтай учир аль ч нутаг нь мал аж ахуй эрхлэхэд (ялангуяа нутаг бэлчээр сэлгэдэг нүүдлийн) ихээхэн тохиромжтой нутаг юм. Гадаргын усан хангамж жигд, уур амьсгал нь хуурайвтар сэрүүн бэлчээрийн ургамлын нэр төрөл олон зэрэг нь мал аж ахуйд ихээхэн тохиромжтой нөхцөл бүрдүүлдэг тул эртнээс нааш нүүдэлчдийн тогтвортой нутагладаг байнгын нутаг байв. Нүүдлийн соёл иргэншлийн хэв шинжийг Хяргас суманд тодорхой харж болно. Хяргас сум 1995 оны эхээр 97.533 мянган малтай, тэмээ 854, адуу 6597, үхэр 7823, хонь 62394, ямаа 19815 толгой буюу бодод шилжүүлснээр 28385 малтай, мал аж ахуй зонхилон эрхэлдэг аж ахуйн үндсэн хэвшилтэй сум юм. Сумын нутгийн зүүн хойд хэсэгт Баруунтуруун, Хангилцаг голын савд бага зэрэг талбайд газар тариалан эрхэлж, гол төлөв үр тариа тарих боловч, түүнд ажиллагсад цөөн, аж ахуйн ач холбогдол их биш юм. Тус суманд үйлдвэр үйлчилгээний хувьд сум дундын ач холбогдолтой байгууллага байхгүй, хүн амын өрхийн гишүүдийг нь оролцуулаад 85 % нь мал аж ахуй эрхэлж 1996 онд амьдарч байна. 1990 оноос хойш мал аж ахуйд ажиллагсадын тоо байнга өсч, улс ардын аж ахуйн бусад салбарт ажиллагсадын тоо, хувийн жин жил дараалан буурч байна. Хяргас сумын хүн амын 90 % нь баяд угсаатан бөгөөд баядын ахуй зан заншил хамгийн их хадгалагдаж хоцорсон нутаг юм. Иймч учраас баяд угсаатан нутагшлын бөөгнөрөл үүсгэн оршин суудаг Увс аймгийн Тэс, Зүүнговь, Малчин, Хяргас, Наранбулаг (хүн амын 50% нь баяд) сумдаас Хяргас сумыг сонгон авч судалсан юм.

Баяд ястны өрх гэр бүлийн хүн ам зүйн судалгаа

1. Хүн ам зүйн үндсэн үзүүлэлтийн судалгаа

Монгол улсад 20 шахам угсаатан ястан оршин суудгаас ойрдын язгуурын баяд угсаатан хүн амынхаа тоогоор халх, хасаг (казах) дөрвөдийн дараа 4-рт ордог. Монгол улсад оршин суудаг баядууд 1989 оны хүн амын тооллогын дүн мэдээгээр 39.2 мянга бөгөөд хүн амын өсөлтөөрөө хасаг халхын дараа 3-рт орно. Баядуудын 60.4 хувь нь нутагшлын бөөгнөрөл

үүсгэн унаган нутаг болох Увс аймгийн Тэс, Зүүнговь, Хяргас, Малчин сумдын бүх нутаг зэргэлдээх Наранбулаг сумын зүүг хасаст оршин суудаг. 1970-аад оны сүүл хагас хүртэл баяд угсаатнууд нутгаасаа гадагш шилжин суух эрчим багатай байсан мал аж ахуй бараг дагнан эрхэлж байсан учир үндэснийхээ нийтлэг болон онцлог сайн хадгалж хоцорсон юм. Хяргас сумын баядууд нь угсаатныхаа унаган төрх, ахуй, заншлыг илүүтэй хадгалж үлдсэн байна. Баяд угсаатан оршин суудаг сумдаас Хяргас сум хүн амынхаа тоогоор Тэс сумын дараа 2-рт орно. Хяргас суманд ажиллах хүчин байнга хүрэлцээтэй байдгын нөлөөгөөр энэ суманд өөр аймаг сумаас хүн ам шилжин ирж суурьших нь тун бага байсан тул нутгийн ахуй соёл, заншилд бусад угсаатны нөлөөл бага байна. Хяргас сумын хүн амын өсөлт улсын хөдөөгийн хүн амын өсөлтийн дунджаас бага зэрэг давуу байдаг боловч гадагш ажиллах хүчний шилжүүлэх боломжийн улмаас жил бүр тус суманд төрсөн хүүхдийн тооны 60-80%-тай тэнцэх тооны хүн ам гадагш шилжин нутаглаж байсан тул хүн ам нь байнга тогтмол буюу аажмаар өсч байв. Хүн амын тоо бүртгэл сайтар хийгдэхгүй байснаас сумын хүн ам зарим жил огцом цөөрч, нэмэгдэж байсан мэт харагдах нь бий. Жишээ нь 1991 онд сумын хүн ам огцом өссөн мэт харагдах боловч энэ нь хүнсний бүтээгдэхүүний картаар олгох болсноос бүртгэлгүй байсан хүмүүс бүртгүүлэх аймгийн төв, Баруунтуруун, Цагаанхайран сумдад түр сууж байсан хүмүүс буцаж ирснээр тайлбарлагдана.

Увс аймаг Хяргас сумын хүн амын тоо
(оны эхэнд)

Он	Нийт дүн	Үүнээс		Өрхийн тоо	Үүнээс сумын төвийн хүн ам			
		эр	эм		Бүх хүн ам	Үүнээс		Өрхийн тоо
						эр	эм	
1977	3535			743				
1978	2994			726				
1979	2918			694				
1980	3051			710				
1981	3052			716				
1882	3014			700				
1983	3017			735				
1984	3003			750				
1985	3019			767				
1986	3006			730				
1987	3115			770				
1988	3064			785				
1989	2982	1512	1470	790				
1990	3110	1545	1565	812				
1991	3527	1817	1710	810	1598	817	781	373
1992	3710	1883	1827	838	1558	786	772	377
1993	3705	1919	1786	862	1307	656	646	320
1994	3698	1919	1779	874	1056	600	556	290

1991,1992 онд улс орон даяар ажилгүйдэл эрс өссөний нөлөөгөөр Хяргас сумаас ажиллах хүч улс орон даяар ажилгүйдэл эрс өссөний нөлөөгөөр Хяргас сумаас ажиллах хүч улс орны төв хэсэг рүү шилжих нь зогссон, картаар олгох хүнсний барааг авахын тулд хүн ам (ялангуяа хүүхдийн), өрхийн тоог өсгөн мэдээлж байсан зэргийн нөлөөгөөр хүн ам хурдан өссөн мэт харагддаг. Харин 1993, 1994 онд хүн амын тоо багассан нь хүн амы төрөлт багассан, нөгөө талаар картын систем арилж хүн амын тоог хий өсгөн мэдээлэх явдал арилж байгаатай холбоотой юм. 1991,1992 онд мал хувьчлахтай холбогдож өөр сумд, аймгийн төв, бүр заримдаа улс орны төв хэсгээс хүн ам, хөдөө нутагт түр шилжин ирж, мал хувьчилж аваад, 1993,1994 онд авсан малаа зөрж ирээд буцаж шилжсэн нь хүн амын тооны өөрчлөлтөнд нөлөөлсөн тал бий. Мөн цэрэгт алба хаагсадын, ТМС-д элсэгчдийн тоо цөөрснөөс залуус шилжин явах нь багасаж, хүн амын тоо нас, хүйсний бүтцийг хэвийн болгоход бага боловч нөлөөлжээ.

Увс аймгийн Хяргас сумын хүн амын угсаатны судалгаа

Д/Д	Ястны нэр	Тоо оноор				
		1990	1991	1992	1993	1994
1	Баяд	3095	3511	3692	3686	3676
2	Халх	5	6	7	8	9
3	Дөрвөд	8	7	8	8	10
4	Хотон	1	1	1	1	1
5	Бусад	1	2	2	2	2
	ДҮН	3110	3527	3710	3705	3698

Хяргас сум бол нэг угсаатан дагнан нутагладаг сумдын нэг бөгөөд энэ үзүүлэлтээрээ Монгол улсын хэмжээнд дээгүүр байр эзэлдэг. Хамгийн сүүлчийн бүтээлээс үзвэл сумын хүн амын 99.7 % нь баяд угсаатан байгаа юм. Энэ суманд нөхөр, эхнэр хоёр хоёулаа баяд бус угсаатнаас бүрдсэн өрх байхгүй байгаа нь онцлог байна. Ийм учраас Хяргас сум бол баяд угсаатны ахуй, заншил, аялгуу, урлаг соёл, хөдөлмөрийн дадлыг төлөвшүүлэн судлахад хамгийн тохиромжтой сум болно. Хяргас сумын баяд угсаатны насны бүтцэд онцгой нөлөөлөх нийгэм, эдийн засгийн үйл явц болоогүй учраас хүн амын насны бүтэц ихээхэн зохистой байдаг.

Увс аймгийн Хяргас сумын хүн амын насны бүтэц

Насны бүлэг	Бүх хүн ам	Үүнээс		Хувь
		Эр	Эм	
0-4	555	314	241	18.6 %
5-9	440	225	215	14.8 %
10-14	412	229	183	13.8 %
15-19	249	112	137	8.3 %
20-24	225	102	123	7.5 %
25-29	223	108	115	7.5 %
30-34	170	92	78	5.7 %
35-39	97	52	45	3.3 %
40-44	81	38	43	2.7 %
45-49	138	64	74	4.6 %
50-54	109	50	59	3.7 %
55-59	85	43	42	2.8 %
60-64	80	40	40	2.7 %
65-69	53	22	29	1.8 %
70-74	-			
75-79	66	20		2.2 %
80-84				
85-89				
90-94				
95-99				
100 – дээш	2982			100.0

Хяргас сум төрөлт ихтэй сумын төвд багтаж байгаа боловч сүүлийн 10-аад жилд жил тутамд төрсөн хүүхдийн тоо нь 33 жилийн өмнөх буюу 1966 онд төрсөн хүүхдийн тоонд хүрэхгүй байгаа юм. 1989 онд үр хөндөлтийг чөлөөтэй болгосны дуулиан, ЭМЯ-аас авч хэрэгжүүлсэн алсын бодлого муутай арга хэмжээ болох үр хөдөлтийг хэт чөлөөтэй болгосон зэргээс шууд шалтгаалан 1990 онд төрөлт эрс буурчээ. 1991 онд үр хөндөлтийг шүүмжлэх нь өсөх үед үр хөндөхийг тухайн үеийн сумын эмнэлгээс түдгэлзэж байсан тул төрөлт 1991 оныхоос 1/3-аар нэмэгдсэн боловч, ЭМЯ-аас 1992 онд үр хөндөлтийг эрчимжүүлсэн, эхчүүдэд ерөндөг ихээр тавих болсон тул төрөлт дахин буурч төрсөн хүүхдийн тоо 35 жилийн өмнөх тоонд хүрч буурав. 1994 оноос эцэг эхчүүд (ялангуяа өрхийн тэргүүлэгчид) ЭМЯ-ны үйл ажиллагааг сөрөх болсноос төрөл нэмэгдэж байна. Гэхдээ төрсөн хүүхдийн тоо 1961 онд хүрээгүй хэвээр байгаа юм. Хүүхэдгүй айл мал маллагаанд хүн хүчээр дутагдаж байгаагаас малчид дүгнэлт хийж байгаагаас тодорхой ярьж, айл өрхүүд (ялангуяа малчид) 4-6 хүүхэдтэй байх нь зөв юм гэсэн баримтлалаа бидэнд хэлж байв. Хүүхэд төрүүлж байгаа эхчүүдийг насаар нь авч үзвэл 18-аас доош насандаа 45- аас дээш насандаа хүүхэд төрүүлэх нь мэдэгдэхүйц багассан байна.

Хяргас сумын хүн амын төрөлт

Он	Нийт төрсөн хүүхэд	Үүнээс		Үүнээс гэртээ төрсөн	Үүнээс эмнэлэг			Үүнээс	
		Эр	Эм		Эр	Эм	Эмнэлэгт төрсөн	Эр	Эм
1959	110	62	48	109	61	48	1	1	
1960	129	63	66	126	61	65	3	2	1
1961	157	75	82	152	75	77	5	—	5
1962	99	48	51	91	44	47	8	4	4
1963	137	63	74	116	58	58	21	5	16
1964	124	50	64	59	25	34	55	25	30
1965	122	58	64	669	30	39	53	28	25
1966	144	68	76	40	40	42	61	28	33
1967	126	67	59	66	33	23	60	34	26
1968	154	86	68	67	37	30	87	49	38
1969	135	64	71	58	25	33	77	39	38
1970	144	69	75	82	40	42	62	29	33
1971	137	75	62	6	37	29	71	38	33
1972	128	66	62	58	28	30	70	38	32
1973	130	56	74	51	29	22	79	27	52
1974	124	57	67	26	9	17	98	48	50
1975	121	61	60	22	15	7	99	46	53
1976	112	58	54	20	8	12	92	50	42
1977	120	61	59	15	8	7	105	53	52
1978	112	59	53	16	8	8	966	51	45
1979	106	54	52	7	3	4	99	51	48
1980	130	67	63	16	8	8	114	59	55
1981	121	65	56	8	6	2	113	59	54
1982	106	58	48	3	2	1	103	56	47
1983	102	48	54	—	—	—	102	48	54
1984	112	54	58	—	—	—	112	54	58
1985	88	51	37	—	—	—	88	51	37
1986	115	61	54	—	—	—	115	61	54
1987	98	47	51	—	—	—	98	47	51
1988	131	76	55	—	—	—	131	76	55
1989	136	69	67	—	—	—	136	69	67
1990	116	57	59	1	—	1	115	57	58
1991	152	76	75	1	—	1	150	76	74
1992	119	54	65	1	—	1	118	54	64
1993	125	60	65	—	—	—	125	60	65
1994	142	81	60	16	8	8	1266	73	52

Хяргас сумын төрсөн эхчүүд насны бүлгээр (1994)

18 нас хүртэл	1976	0	
19-20	1974-1975	10	7.2 %
21-25	1969-1973	74	53.2 %
26-30	1964-1968	38	27.3 %
31-35	1959-1963	14	10.1 %
36-40	1954-1958	1	0.7 %
41-45	1949-1953	1	0.7 %
46-50	1944-1948	1	0.7 %
51 ба дээш	1943	0	
Бүгд		139	100 %

Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 80.5% нь 21-30 насандаа хүүхэд төрүүлэх болов. Ер нь 37 наснаасаа хойш хүүхэд төрүүлэх нь мэдэгдэхүйц буурч байгаа Монголын нийтлэг байдал энэ суманд ч ажиглагдаж байна.

Хяргас сумын хүн амын нас баралт

Хүн амын нас баралтын тооны өсөлт нь хүн амын тооны өсөлтөөс ямар нэг хэмжээгээр түрүүлэх байдал сүүлийн 10 жилд харагдаж байна. Энэ нь малчдын дунд өвчлөл их байгаа эмнэлгийн эмчилгээний чанар сайжрахгүй байгаагаас голлон шалтгаалдаг. 1992 онд нас барсан хүний тоо 1985, 1986 онд хоёр жилд нас барсан хүний тооноос 20 гаруй хувь давсан нь 1991, 1992 онд нийгэм мэдэгдэхүйц хямарсны нууц уршиг юм. Төр засгийн удирдлагын алдаа завхрал, хүн амд, тэр тусмаа хөдөөгийн хүн амд яаж тусдаг нь Хяргас сумын хүн амын нас баралт нэмэгдэж, төрөлт буурч байгаагаар тодорхой харагдаж байна.

Хяргас сумын хүмүүсийн нас баралт, насны бүлгээр (1994)

1 нас хүртэл	3	8.8 %
1-15 нас	5	14.7 %
16-25	1	3 %
26-50	4	12 %
51-75	17	50 %
76 ба дээш	4	12 %
БҮГД	34	100 %

Нас барагчдыг насны бүлгээр авч үзэхэд 1-15 насны хүүхдийн нас баралт улсын дундажаас өндөр байгаа нь эмч мэргэжилтний хариуцлага, чадвар сул, эмнэлгийн үйлчилгээ муу байгааг харуулж байна. Нийт нас барагчдын 23.5 % буюу бараг 1/4 нь 15 хүртлэх насны хүүхэд байгаагаас сумын хүн

амын өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлж эхэлнэ. Хяргас суманд хүүхдийн өвчлөлт, нас баралт багасгах талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээг даруй хэрэгжүүлэх шаардалагтай болжээ.

Хяргас сумын хүн амын нас баралт

Он	Бүгд	Үүнээс	
		Эр	Эм
1959	17	6	11
1960	11	5	6
1961	13	7	6
1962	18	7	11
1963	21	12	9
1964	11	8	3
1965	6	5	1
1966	9	6	3
1967	15	8	7
1968	3	1	2
1969	9	5	4
1970	13	10	3
1971	19	7	12
1972	22	11	11
1973	10	5	5
1974	11	7	4
1975	25	15	16
1976	16	10	6
1977	14	9	5
1978	11	4	7
1979	8	7	1
1980	39	18	21
1981	26	12	14
1982	39	20	19
1983	41	22	19
1984	43	19	24
1985	40	21	19
1986	31	21	7
1987	26	8	18
1988	31	16	15
1989	35	25	10
1990	33	24	9
1991	45	1	29
1992	52	31	21
1993	31	12	19
1994	34	1	18

Хяргас сумын 0-1 насны хүүхдийн нас баралт

Он	Бүгд	Үүнээс	
		Эр	Эм
1959	4	—	4
1960	4	1	3
1961	3	2	1
1962	8	3	5
1963	3	2	1
1964	5	5	—
1965	3	3	—
1966	1	—	1
1967	4	3	1
1968	—	—	—
1969	1	1	—
1970	2	1	1
1971	1	—	1
1972	4	1	3
1973	—	—	—
1974	—	—	—
1975	5	5	—
1976	1	1	—
1977	—	—	—
1978	—	—	—
1979	1	1	—
1980	7	4	3
1981	8	5	3
1982	14	6	8
1983	13	2	11
1984	10	3	7
1985	9	5	4
1986	—	6	—
1987	2	2	—
1988	6	3	3
1989	7	7	—
1990	4	3	1
1991	19	11	8
1992	10	6	4
1993	6	2	4

1950-иад оны эхэн дунд үеэс хүн амыг эрүүлжүүлж, төрөлтийг нэмэгдүүлсний шууд үр дүнгээс уламжлан 1974 оноос гэрлэлт эрс нэмэгджээ.

Нас баралт хүүхдийн нас баралт улсын дундажтай харьцуулахад тариуцлага, чадвар сул, эмнэлгийн үйлчилгээний байдал, заруулам байна. Нийт нас барагчдын 23.5% буюу 34 нас 13-хүрмийн насны хүүхдн байгаагаас сумын хүн

Хяргас сумын гэр бүл болсон хүн ам, салалт, хүүхэд үрчлэлт

Он	Гэр бүл болсон	Салсан	Үрчилсэн хүүхэд
1970	18		3
1971	28		4
1972	46		—
1973	20		5
1974	32		
1975	36		3
1976	48		3
1977	46		2
1978	38		2
1979	32		6
1980	30	4	1
1981	34	2	3
1982	24		2
1983	24		1
1984	34	2	2
1985	30		3
1986	46		4
1987	42		3
1988	28		2
1989	2		1
1990	84		2
1991	94		5
1992	104		2
1993	94	2	2
1994	60		1

1991, 1992 онд гэрлэлт эрс нэмэгдсэн нь нэгдлийн малыг хувьчлах үед өрхөөр мал хувьчлахад голлон анхаарсан явдлаар тайлбарлагдана. 1993 оны сүүл хагасаас малыг үндсэнд нь хувьчилж дуусахад гэрлэлт огцом буурчээ. Харин 1992, 1993 оны гэрлэлтийн өсөлтийн нөлөөгөөр төрөлтийн бууралт багасаж, тогтворжих, өсөх хандлага илэрхий болов. Залуус улс орны төв хэсэг рүү ажиллах, суралцахаар шилжин явах хөдөлгөөн багасаж, малаа өсгөх бололцоо нэмэгдсэн нь гэрлэлт өсөхөд зэрэг нөлөө үзүүлнэ. Хяргас суманд гэр бүл салалтын тоо харьцангуй маш бага байдаг өвөрмөц онцлог сүүлийн 25 жилд хадгалагдсаар байна. Хяргасынхан гэрлээд 3 жил болоход хүүхэд төрөхгүй бол хүүхэд үрчилж авдаг өвөрмөц онцлогтой, ялангуяа 1991 онд мал хувьчлахад өрхийн ам бүлийн тоог харгалзсантай ямар нэг хэмжээгээр уялдаж, хүүхэд үрчилсэн тоо өссөн юм.

Хяргас сумаас сургууль, цэрэгт явсан хүмүүсийн тоо

Он	Цэрэгт явсан	Цэргээс ирсэн
1985	37	37
1986	23	23
1987	36	36
1988	44	44
1989	32	32
1990	21	21
1991	—	—
1992	21	21
1993	14	14
1994	15	15

Энэ суманд хүн ам гадагш шилжин явах нь шилжин ирж суурьшихаас байнга давамгайлж байдаг юм. Бидний судалгаа явуулах үед хүн амын шилжих хөдөлгөөний бүртгэл мэдээ хариуцсан ажилтан нь Улаанбаатар руу явсан байсан учир сүүлийн жилүүдэд хүн амын шилжих хөдөлгөөний тухай албан ёсны бүртгэл мэдээ авч чадаагүй. Ямар боловч суманд төрсөн, нас барсан хүний мэдээ бүртгэлд судалгаа хийхэд, гадагш шилжин явагсадын тоо буурсан хэдий ч шилжин ирэгсэдийн тооноос давсан хэвээр байна. Хүн амын шилжих хөдөлгөөнд цэргийн албыг тооцохгүйгээр зохион байгуулалтгүй урсгалаар буюу хувийн хүсэл зоригоор шилжин явдаг ганцхан хэлбэр зонхилж байна.

Өрхийн судалгаа

Хяргас суманд баяд айл өрхийн хүн ам зүйн үндсэн үзүүлэлтийг тодотгох зорилгоор 100 өрхийн судалгаа явуулж, урьдчилан боловсруулсан асуулгын хуудсыг (анкетыг) бөглүүлэх аргаар явуулав. Асуултыг судлаач өөрөө асууж, хариултыг сонсоод, судлаач өөрөө бөглөсөн тул асуултанд буруу зөрөө хариулсан бөглөсөн явдал тун цөөн гарсан гэж үзэх үндэслэл сайтай болов.

Судалгаанд хамрагдсан 100 өрхийн 87 бүтэн өрх (эцэг, эх нь хүүхдүүдийн хамт аж төрдөг) юм. 100 өрхийн 91 баяд нөхөр, эхнэрээс бүрдсэн буюу нэг угсаатан дагнасан өрх байна. Найман өрх нь баяд угсаатан хүн дөрвөд, халх, хотон, торгууд, мянгад хүнтэй (тус бүр нэг) гэрлэж үүссэн өрх байлаа. Судалгаанд хамрагдсан өрхийн 91 нь төрсөн нутагтаа оршин суугаа өрх юм. Мөн 100 өрхийн 79 өрх нь нутгаасаа буюу Хяргас суманд төрсөн хүмүүс хоорондоо гэр бүл болсноос бүрдсэн өрх байлаа.

Судалгаанд хамрагдсан 100 өрхийн 12 нь бэлэвсэрсэн өрх байгаагаас 10 нь эмэгтэйчүүд толгойлсон өрх, эхнэр нь нас барсан өрх бүтэн өнчин хүүхдүүдээс бүрдсэн өрх 12 байв. Зуун өрхийн 80 нь хүүхэдтэйгээс үрчлэгдсэн айлдаа өсөн торниж буй хүүхэд 4 бүртгэгдэв. Долоон өрх насан өндөр эцэг эхээ ам өрхдөө багтаан асрамжлан тэтгэж өсгөж явдаг. Хяргас суманд эцэг эх нь өрх тусгаарласан хүүхэдтэйгээ айл саахалт, эсвэл нэг багтаа, зэргэлдээ

багтаа өрх тусгаар амьдардаг заншил хэвшжээ. Насан өндөр болсон (гол төлөв 65-аас дээш насны эрэгтэй, 60- аас дээш насны эмэгтэйчүүд) ганц бие хөгшид өвгөд нь хөдөө мал дээрээ байдаг үр хүүхдээ, эмгэд нь баг, сум, аймгийн төв, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод үр хүүхдээ бараадан тэднийхээ асрамжинд амьдрахаар шилжин суурьшдаг нь илт ажиглагдлаа. Энэ нь Монгол орны хүн амын нийтлэг нэг зүй тогтолтой тохирч байгаа юм. Зуун өрхийн зургаагынх нь эцэг эх Улаангом, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт Ховд, Хэнтий Сэлэнгэ, төв аймагт тавынх нь эцэг эх зэргэлдээ суманд аж төрдөг байна. Нэг гэр бүлд одоо хамт амьдарч байгаа 83 өрхийн эхнэр, нөхрийн төрсөн газрыг сонирхвол орон нутгийн онцлог тодорхой харагдаж байв.

Нөхөр, эхнэр хоёрын төрсөн газрын зай

10 км-ээс ойр нутагт	5	6 %
11-20 км зайтай нутагт	7	8.4 %
21-40 км зайтай нутагт	48	57.8 %
41-80 км зайтай нутагт	12	14.5 %
81-160 км зайтай нутагт	4	4.8 %
161-320 км зайтай нутагт	6	7.2 %
321-640 км зайтай нутагт		
641км- ээс зайтай нутагт	1	1.2 %

1. Зайг тооцохдоо 5 км хүртэл алдсан байж болохыг үгүйсгэхгүй. Зуун өрхийн хүүхэдтэй 80 эрхийн 7 айлд нь эцэг эхийн төрсөн нутгаас өөр сум, аймаг хотод төрсөн 14 хүүхэд байсан бөгөөд 6 нь зэргэлдээх Баруунтуруун суманд (сум дундын эмнэлгийн эмчилгээ үйлчилгээ Хяргас сумынхаас давуу байснаас) 3 нь Цагаанхайрхан суманд (Хяргас зүүн захын айлууд энэ суманд 15-25 км буюу ойр нутагладгаас) 2 нь Улаангомд (эмнэлэг үйлчилгээ сайн байсан), хүүхэд төрөх үед эцэг эх нь тэнд амьдарч байсан хоёр шалтгаанаас) Улаанбаатар хотод 1, Завханд 2, (эцэг эх нь тэнд ажиллаж байсан) гэжээ.

Нөхөр эхнэрийн насны зөрөө

Нас чацуу	10
Эхнэр нь нөхрөөсөө эгчмэд	10
Нөхөр нь эхнэрээсээ 1-2 насаар ах	33
3-4 насаар ах	23
5-6 насаар ах	4
7-8 насаар ах	6
9-10 насаар ах	7
Нөхөр нь эхнэрээсээ үе мултарсан ах	1

1. Бэлэвсэрсэн зарим хүн асуултанд хариулаагүй.

Нөхөр эхнэрийн насны зөрөө харьцангуй бага суманд Хяргас сумыг багтааж болно. Судлагдсан өрхийн нөхөр эхнэрийн 80.9 % нь хоорондоо 1-4 насны зөрөөтэй эсвэл нас чацуу байв. Эхнэр нь нөхрөөсөө эгчмэд гэж бүртгэгдсэн

10 өрхийн эхнэр нь нөхрөөсөө 12.2 насаар эгчмэд байв. Энд энхэр нь эгчмэд гэж бүртгэгдсэн өрхүүдийн амьдарлын түвшин харьцангуй сайн буюу энэ 10 өрхийн орлого нь зарлагаасаа давдаг буюу ногдох (орлого хангалттай хүрэлцээтэй) гэж хариулсаныг тэмдэглэе. Бид үүний шалтгааныг судалгаа авч байх үедээ тодорлуулахыг (саналгүй өнгөрч, мэдээлэлд боловсруулалт хийх үедээ ашиглав. Энэ нь бидний судалгааны арга туршлагад дутуу зүйл байгааг харуулсан тул цаашдын судалгаанд анхаарна.

**Гэр бүлийн хоёр гишүүний (нөхөр, эхнэрийн)
боловсролын байдал**

Ижил боловсролтой	51
Үүнээс бага сургуулийн боловсролтой	19
Бүрэн бус дунд	14
Бүрэн дунд	4
Тусгай дунд	2
ТМС	4
Дээд	1
Боловсрол ажилгүй	49
Үүнээс нөхөр нь эхнэрээсээ боловсролоор илүү	21
Эхнэр нь боловсролоор илүү	19

Сургуульд сурч байгаад дуусгаагүй, сурч байгаагүй гэсэн өрх 9 бий.

Нөхөр эхнэрийн мэргэжил

Ижил мэргэжилтэй	7
Мэргэжил өөр	7
Зөвхөн нөхөр нь мэргэжилтэй	12
Зөвхөн эхнэр нь мэргэжилтэй	3
Хоёулаа малчин	71

1. Судалгаанд хамрагдсан 100 өрхийн хүрээнд

2. Хоёулаа малчин гэж хариулсан өрхийн эхнэр, нөхрийн аль нэг нь мэргэжил эзэмшсэн (ялангуяа ТМС төгссөн) боловч мэргэжлээрээ ажиллаагүй удсан цаашид мэргэжлээрээ ажиллах ирээдүйгүй гэж үзэж малчин гэж хариулсан хүмүүс цөөнгүй буй. Зөвхөн нөхөр нь мэргэжилтэй гэж бүртгэгдсэн өрхийн нөхрүүдийн 50 % мэргэжлийн ажлаа хийж байхад зөвхөн эхнэр нь мэргэжилтэй гэж бүртгэгдсэн өрхийн эзэгтэй нар цөм мэргэжлийн ажлаа хийж байгаа гэснээс үзвэл эмэгтэйчүүд мэргэжлээрээ ажиллах болоцоо Хяргас суманд илүү байгаагаар өвөрмөц байв. Эрэгтэйчүүд мэргэжлийн ажлаас өөр ажил (гол төлөв мал маллах) эрхлэх, эрхэлсэн тодорхой ажилгүй байх, худалдаа наймааны ажил эрхлэх нь олонтлоо тохиолдож байв. Дээд мэргэжил л биш бол ТМС, тусгай ба тусгай дунд, мэргэжил ажилгүйдэлд хялбар нэрвэгддэг учир үр хүүхдээ өөрсдийн мэргэжлээ эзэмшүүлэхэд ирээдүйгүй гэсэн санааг нилээд хэд хэдэн хүн ярьж байлаа.

Өрхийн байршил

Сумын төвд нутагладаг өрх	21
Багийн төвд нутагладаг өрх	11
Хөдөөд (мал дагнан эрхэлж) нутагладаг өрх	68
Хөдөөгийн өрх бүгд	19
Үүнээс: сумын төвд 10 км-ээс ойр өвөлждөг	3
11-20 км-т	14
21-40 км-т	30
41-80 км-т	27
81-160 км-т	5

Өрхийн байршлыг гаргахдаа, хамгийн удаан хугацаагаар, тогтвортой нутагладаг өвөлжөөгөөр аюч үзэв.

Хяргас сумын айл өрх өвөлжөөндөө 11 сарын сүүлчээс 4-р сарын эх хүртлэх хамгийн удаан хугацаагаар (110-140хоног) нутаглах ба өвөлжөө сольж өвөлжих нь хаваржаа, зуслан, намаржаа солихоос 2-3 дахин цөөн байна. Хаваржаанд (1-3 удаа буйр сольж) 70-90 хоног, зусланд 2-3 удаа нүүж 60-80 хоног, намаржаанд 2-4 удаа нүүж, 50-90 хоног нутагладаг байна. Хаваржаа, намаржаа нь зусланг бодвол харьцангуй ойрхон байдаг. Өвөлжөөндөө байшин, малын хашаа саравчтай байх тул өвөлжөө солих нь хамгийн цөөн буюу өвөлжөө нь нутагшилтын төв болно.

Өрхийн шилжих хөдөлгөөн

Одоогийнхоос өөр баг сум, аймаг хотод амьдарч байсан өрх	33
Үүнээс: Сум дотроо шилжин нутагласан айл	27
Өөр суманд байсан айл	2
Аймгийн төвд байсан айл	2
Багаасаа гадагш шилжин сууж байгаагүй өрх	67

Хяргас суманд гаднаас айл өрх шилжин ирж нутагших явдал ховорхон, хаяа биш, хүн малын эмч, удирдах ажилтнууд гэр бүлийн хамт шилжин ирдэг байсан боловч энэ нь сүүлийн 5 жилд зогсжээ. Хяргас сумаас улс орны төв ба дорнод нутагт гэр бүлээрээ шилжин суух нь элбэг байсан (гэхдээ Увс аймгийн бусад сумадтай харьцуулбал эрчим султай) боловч сүүлийн 5 жилд мөн багасчээ. Сумын төв 1988-1989 онд 20-иод км газар шилжин суурьшсаны улмаас сумын дотор айл өрхүүд шилжин нүүх явдал өрнөж, 300 шахам өрх нүүдэллэжээ. 1991-1992 онд мал хувьчилсны дараа 1993 оныг дуустал сумын болон бригад, багийн төвөөс хэдэн арван өрх хөдөө шилжин нутаглав. Сумын төвийг тооцохгүй бол бригад, багт нутагладаг айл

өрхүүд нэг баг, бригадаас нөгөө баг, бригадад шилжин суурьших нь ховох юм. Харин улирлын нүүдэл хийхдээ Малчин баг, бригадад шилжин суурьших нь ховор юм. Харин улирлын нүүдэл хийхдээ малчин сумыг гүйцэхгүй боловч, өвөлжөө (гол төлөв Хан хөхийн өвөр лүү) зуслангийн (Хөхийн ар руу 40-180 км нүүдэг.

Хяргас сумын өрх малын судалгаа

Он	Өрхийн тоо	Малын тоо	Үүнээс				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1970	715	99850					
1971	706	101056					
1972	728	100207					
1973	712	108524					
1974	748	100643					
1975	752	97904					
1976	756	90078					
1977	743	81006					
1978	726	84376					
1979	694	88049					
1980	710	86009					
1981	716	87752					
1982	700	85318					
1983	735	86121					
1984	750	86233					
1985	767	89184					
1986	730	93111					
1987	770	94826					
1988	785	98214	1554	8048	7069	63261	18282
1989	790	101967	1570	8403	7403	64965	19626
1990	812	104453	1446	8570	7676	66966	20195
1991	810	95711	1209	7737	6736	62627	17402
1992	838	93012	990	6865	6344	62228	16615
1993	862	93832	926	6272	6620	69984	17630
1994	874	97533	854	6597	7823	62394	19865

Нэг өрхөд дунджаар 111,6 мал оногдож байгаа улсын дунджаас (малчин өрхөд оногдуулсан тооцоогоор) бага зэрэг илүү байна. таван хошуу малын тооны харицаа харилцангуй зохистой байсан уламжлал алдагдаж байгаа ч өрхийн амьжиргаа, орлогод төдий л сөрөг нөлөөлөхгүй юм. Сүүлийн 10 жилд тэмээний тоо толгой бараг 2 дахин (ялангуяа 1992,1993 онд) хорогдов. Бусад малын тоо ч өсөхгүй, аажмаар хорогдож байна. Малын өсөлт зогсонги, үйлдвэрлэл (угийн бага) үйлчилгээний газар цөөн учир малчид, ялангуяа сумын төвийн айл өрхийн амьжиргааны нөхцөл ихэнхдээ урууданги байгаа гэнэ. Бусад аймаг сумаанд хурдан өсч буй ямаан сүргийн тоо ч Хяргас суманд бараг өссөнгүй. Гахай шувууны салбар арилжээ. Өрхийн тоо нэмэгдэхийн хирээр нэг өрхөд ногдох малын тоо аажмаар цөөрч байна.

Өрхийн малын тоо

10-аас цөөн тооны малтай	4
11-20 толгой малтай	3
21-40 толгой малтай	7
41-80 толгой малтай	25
81-160 толгой малтай	30
161-320 толгой малтай	22
321-640 толгой малтай	8
641-1000 толгой малтай	1

Малгүй 1000 олон малтай гэсэн гэсэн асуултанд хариулсан өрх байхгүй. Айл өрхүүд 5 хошуу малыг тэнцүүхэн өсгөх сонирхол, уламжлалтай байдаг. Харин сүүлийн 5 жилд өрхөд оногдох тэмээ 20 гаруй дахин, адуу 30 гаруй хувь, хонь 10 гаруй хувиар үхэр ямаа 5 хувиар хорогдов. Айл өрхийн амьжиргааны хэрэгцээг дан мал аж ахуйгаас халж байх нөхцөлд нэг өрхөд дунджаар 300-аас олон толгой мал оногдож байвал (Хяргас сумын нөхцөлд) боломжтой гэж сумын удирдлагууд, мэргэжилтнүүд үздэг боловч нийт өрхийн дөнгөж 10 хувь нь 300-аас олон толгой малтай байна. Өрхийн 30 гаруй хувь нь 10 хүрэхгүй толгой малтай (120-иос доош толгой мал нөхөн үржих боломжгүй гэнэ) байгаа ядуурал, эрсдлийг нэмэгдүүлж байгаа юм байна. 1995 оны 9 сарын байдлаар 1000 малтай өрх байсангүй.

Өмч хөрөнгийн байдал

Ачааны машин трактортой	4
Мотоциклтой	19
Хөргөгчтэй	4
Цахилгаан үүсгүүртэй	17
Радио хүлээн авагчтай	62
Үүнээс радио нь ажиллаж буй	32
Хивстэй	67

Ахуйн хэрэгцээ тээврийн зориулалттай өмч хөрөнгийг голчлон авсан нь манай судлагааны дутагдал байж магадгүй. (Судалгааны явцад өрхийн өмч хөрөнгийн бэл бэнчинд эмээл, хазаарын мөнгөлөгдсөн байдал, мөнгөн аяга, мөнгөн хэт бэл, үнэтэй гаанс хөөрөг зэргийг тооцдог болохыг ажиглав.

Айл өрхийн өмч хөрөнгийн ялгаа зөрөө мэдэгдэхүйц ажиглагддаг суманд Хяргасыг хамруулж болох юм. Ядуу чинээлгийн ялгаа тодорхой харагдаж байв. Мал аж ахуйгаас өөр орлого олох салбаргүй, хот аймгийн гол замаас зайтай орших тул худалдаа арилжаа, үйлдвэрлэл хөгжих боломж хязгаарлагдмал байдаг нь айл өрхийн амьдралын түвшнийг эрс дээшлүүлэхэд бэрхшээл буй болгодог. Ачааны машин тракторууд нь нэлээд

хуучирсан тул айл нүүлгэх зэрэг сумын доторхи тээврийг гүйцэтгэх боловч аймаг хотын хооронд найдваргүй учир орлогын хэрэгсэл болж чаддаггүй. Бензиний олдоц муу тул цахилгаан айл өрхүүдэд чухал үед л ашигладаг байна.

Өрхийн орлого

Цалин, тэтгэвэр, мал аж ахуйгаас өөр орлогын эх үүсвэргүй өрх	78
Дээрхээс нэмэлт орлоготой өрх	22
Өрхийн орлого нь хангалттай айл (хуримтлал үүсч буй)	12
орлого нь хүрэлцдэг (хуримтлал үүсгэж амжихгүй байгаа	55
Өрхийн орлого нь зарлагаа нөхөж чаддаггүй	34
(хүрэлцдэггүй) айл	

Айл өрхийн 1/3-аас илүү нь ядуу хомс орлоготой гэж асуулганд хариулсныг сумын удирдлага хүлээн зөвшөөрч байв. Хэрэглээний түвшин харьцангуй бага хэдий ч судалгаанд хамрагдсан өрхийн 89 % нь орлогоороо зарлагаа нөхөж чадахгүйн эрхэнд малаа арилжиж аргацаадаг, иймээс малын тоо толгой жил жилээр буурч байгаа, 100 малтай айл 5 жилийн дараа (ийм байдлаар хэвээрээ байвал) малгүй болно гэж малчид ярьж байна. Түлш (Хан хөхийн ойг ашиглаж) ус төлбөр зардалгүй байх байгалийн нөхцөл л малчдыг ядуурал үгүйрлээс хамгаалдаг бололтой. Малын сүү саалийг борлуулах зах зээлгүйгээс малын сааль сүүг ашиглахад төдий л анхаарахгүй байна. Хяргасын малчид, хүн амын орлогыг нэмэгдүүлж, амьдарлын түвшинг нэмэгдүүлэхэд нилээд доривтой арга хэмжээ л үр дүнгээ өгөх юм.

Орон сууцны байдал

Амины гэр байшин хоёртой	61
Зөвхөн гэртэй	43
Зөвхөн байшинтай	-
Гэрт голлон амьдардаг	94
Байшинд голлон амьдардаг	6
5 ханатай гэртэй айл	6
6 ханатай гэртэй айл	77
8 ханатай гэртэй айл	17

Хан Хөхийн нуруунаас ой модны боломжийг ашиглаж модон байшин, эд бараа хадгалах сав пүнзийг 1970–1985 онд олноор барьсан нь хүн амын орон сууцны хангамжийг их сайжруулжээ. Айл өрхийн 90 гаруй хувь нь гэрт зонхилон амьдардаг боловч өвөлжөөндөө 3–5 сар байшинд аж төрөх нь нийтлэг юм. Хан хөхий, Тэсийн мод, бургас хаяанд байх тул айлууд гэрийн мод сайтай. 4 ханатай гэрт амьдардаг айл тун ховор. Айлуудын илүү гэр л 4 ханатай, төдийгүй 5 ханатай айл харьцангуй цөөн, ихэнх 6 ханатай (гэрийн

мод сайтай) гэрт, нилээд хэсэг нь 8 ханатай гэрт аж төрдөгөөрөө Хяргас сумын хөдөөгийн хөдөөгийн хүн ам орон сууцаар сайн хангагдсан нутагт зүй ёсоор багтана. Баяд хонь элбэг учир гэрийг эсгий бүрээс бүрэх боломж сайтай. Сум, багийн төвд тохилог модон байшин олонтой тохиолдоно. Өвөлжөөндөө байшин барих явдал өрнөж байна.

Хүүхдээ сургуулиас завсардуулсан өрх

Сургуулиас завсардсан хүүтэй өрх	30
Сургуулиас завсардсанг охинтой өрх	10

Хяргас сумын айл өрхүүд хүүхдээ сургуулиас завсардуулах явдал нийтлэг болсон сөрөг үзэгдэл юм. Айл өрхийн 40-өөд хувь нь (хөдөөгийн малчин өрхийн хагасаас илүү нь) 1-3 хүүхдээ сургуулиас гаргаж, голдуу гэр малын ажилд туслалцуулах болжээ. Сургуулиас завсардсан хүүхдийн 75 % нь хөвгүүд, 25 % нь охид байна. Сургуульд огт оруулаагүй 9-12 насны хүүхдүүд ч цөөнгүй буй. 1995 онд сургуулиас завсардсан хүүхдийг сургуульд нь оруулах, Цагаанхайрхан сумтай залгаа багт бага сургууль байгуулах арга хэмжээ авсны дүнд сурагчдын тоо өсч эхлэв. Хүүхдээ сургуулиас завсардуулсны хор хохирлыг эцэг эхчүүд сайн мэдэрч байгаа нь цаашид хүүхдээ завсардуулах явдлыг зогсоох эхлэл болж байна. Нөгөө талаар малын тоо толгой эрс өсөх боломж хязгаарлагдмал болж байгаагаас хүүхдийг сургуулиас гаргаж, мал аж ахуйд ажиллуулах хэрэгцээгүй болгож байгаа юм. Сурагчдын дотуур байрны нөхцлийг сайжруулах, сургуулиудыг бэхжүүлэхэд тавих анхаарал нэмэгдсэн зэргээс шалтгаалж хүүхэд сургууль завсардах явдал зогсох төлөвтөө оржээ.

Хяргас суманд явуулсан хүн ам зүйн энэхүү судалгаа нь баяд угсаатны хүн ам зүйн дүр төрхийг тодорхойлоход зохих ач холбогдолтой болсон юм.

Орчин үед гэмт явдлыг шинжлэх ухааны үндэстэн сулрах, түүний үр дүнг ашиглах явдал тунгавдсан чухал зорилт болж байна. Ийм нөхцөлд гэмт хэрэгтэй тэмцэхэд яаж хандаж, яаж зогсоож, яаж хяналт тавихаа судалж, үнэн ёсоор анхаарал татаж байна.

Орчин үед гэмт явдлыг шинжлэх ухааны үндэстэн сулрах, түүний үр дүнг ашиглах явдал тунгавдсан чухал зорилт болж байна. Ийм нөхцөлд гэмт хэрэгтэй тэмцэхэд яаж хандаж, яаж зогсоож, яаж хяналт тавихаа судалж, үнэн ёсоор анхаарал татаж байна.